



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 308

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тариалан эрхлэлтийг дэмжих сан /хуучин нэрээр/-ийн авлага цуглуулах ажлын хүрээнд “Энсада Истерн” хязгаарлагдмал хариуцлагатай компаниас 15 нэрийн нийт 754,942,300.00 (долоон зуун тавин дөрвөн сая есөн зуун дөчин хоёр мянга гурван зуун) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг авлагад тооцон хүлээн авч Хөдөө аж ахуйг дэмжих сангийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал О.Сумъяасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Авлагад тооцон хүлээн авсан газар эзэмших эрх болон үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг хууль, тогтоомжид заасны дагуу шилжүүлэн авч баталгаажуулах арга хэмжээг авах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 07 дугаар сарын 14-ны өдрийн
308 дугаар тогтоолын хавсралт

Хөдөө аж ахуйг дэмжих сангийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж хүчин чадлын үнэ (төгрөг)	Нөхөн орлуулах өртөг (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Өртгийн хандлагаар тооцсон өнөөгийн үнэ цэн (төгрөг)
1	2000 тн-ын үрийн агуулах /1000*2/ Шанаган	2014	м3	5,000	120,000.00	748,440,000.0	119,750,400.0	628,689,600.00
2	дамжуулагч /норий/	2014	м	32	1,195,600.00	38,259,200.0	15,300,700.0	22,955,500.00
3	Туузан дамжуулагч	2014	ш	1	5,807,000.00	5,807,000.0	2,322,800.0	3,484,200.00
4	Чийг мэдрэгч	2014	ш	1	4,336,900.00	4,336,900.0	1,734,800.0	2,602,100.00
5	Буулгах бункерын, норийны доод цутгамал бетон байгууламж	2014	м2	34	664,200.00	28,168,500.0	11,267,400.0	16,901,100.00
6	Урсах хоолой	2014	ш	1	200,000.00	200,000.0	80,000.0	120,000.00
7	Агаар сэлгэх вентлятор	2014	ш	1	550,000.00	550,000.0	220,000.0	330,000.00
8	Буудай гаргах туузан дамжуулагч	2014	ш	1	7,743,000.00	7,743,000.0	3,097,200.0	4,645,800.00
9	Силосын удирдлагын байр /төмөр байр/	2014	ш	1	1,200,000.00	1,200,000.0	480,000.0	720,000.00

10	Угсралтын зардал болон удирдлагын самбар	2014	ш	1		9,089,000.0		9,089,000.00
11	Ажилчдын байр /контейнер сууц/	2014	ш	1	3,500,000.00	3,500,000.0	350,000.0	3,150,000.00
12	Буудай ачигч	2014	ш	1	28,719,400.00	28,719,400.0	11,487,800.0	17,231,600.00
13	60 тн даацтай авто пүү	2014	ш	1	65,000,000.00	65,000,000.0	26,000,000.0	39,000,000.00
14	Пүүлэгчийн сэндвич байр	2014	ш	1	1,800,000.00	1,800,000.0	480,600.0	1,319,400.00
15	Газар эзэмших эрх		га	1				4,704,000.0
Нийт дүн								754,942,300.00 (долоон зуун тавин дөрвөн сая есөн зуун дөчин хоёр мянга гурван зуун төгрөг)